



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

“Баян сэнтий” ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох болон төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.1, 15.1, 15.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баян сэнтий” ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. “Баян сэнтий” ХЗХ-нд санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Баян сэнтий” ХЗХ /Г.Одонзаяа/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000467